



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тавантолгой ХК 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2026/029/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг
2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533552 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn
Солид Юнити аудит ХХК-ийн захирал: Э.Мөнхтогтох
Утас: 99063227 Цахим хаяг: munkhtogtokh.e@solidunity.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	5
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
4.1 Албан шаардлага	20
4.2 Зөвлөмж	23
5.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
НАБТ	Нүүрс ачиж буулгадаг талбай



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ш.ОТГОНБАЯР ТАНАА

2026.03.16 № 305
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тавантолгой ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 7,409,076.5 мянган төгрөгөөр давсан бөгөөд шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Санхүүгийн тайланд бүртгэлтэй нийт авлагын 33.9 хувь буюу 22,343,296.2 мянган төгрөг, урьдчилж орсон орлогын 4.9 хувь буюу 8,915,150.4 мянган төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Гаалийн мэдээ болон цахим тайлангийн системийн мэдээгээр 96,110.7 тонн нүүрс нийлүүлсэн бөгөөд худалдан авагч тал үүнээс 6,377.25 тонн нүүрсийг хүлээн аваагүй гэдэг тайлбартайгаар тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал дахь нүүрсний хөдөлгөөний мэдээ, борлуулалт тээврийн хэлтсийн борлуулалтын мэдээнээс 1,088.7 тонн жингээр зөрүүтэй байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 20.2.6 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, тохиолдсон байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4626050448

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор коксжих нүүрсийг Ханги-Мандлын боомтоор экспортлох анхны тээврийг амжилттай эхлүүлж, шинэ гарц бий болгосон байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд "Эзэмшсэн мэргэжлээрээ-Эх нутагтаа ажиллацгаая" тэтгэлэгт хөтөлбөрийн 2025-2026 оны хичээлийн жилд эдийн засагч, эрх зүйч, мэдээллийн технологи, программ хангамж, сэргээгдэх эрчим хүч, хүрээлэн буй орчны менежмент зэрэг нэн чухал мэргэжлээр сурч буй аймгийн харьяат 23 оюутанд тэтгэлэг олгосон байна.

Компанийн тухай хуулийн 76.1.18, компанийн дүрмийн 7.4.18 дах заалтыг үндэслэн нүүрсний зах зээлийн нөхцөл байдалтай холбогдуулан Компанийн ТУЗ-ийн 2025 оны 2-р сарын 07-ны өдрийн 09 дугаар "Хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай" тогтоолын хүрээнд нийт ажилчдын 80.0 хувийг сул зогсолтод хамруулж, сул зогсолтын үеийн олговрыг үндсэн цалингийн 60.0 хувиар тооцож олгосон бөгөөд уурхайн үндсэн үйл ажиллагаа 2025 оны 8-р сарын 15-ны өдрөөс эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд гүйцэтгэлээр 727,400,236.1 мянган төгрөгийн борлуулалтын орлого, 2,520,816.7 мянган төгрөгийн хүүгийн орлого, 108,101.4 мянган төгрөгийн бусад орлого, 10,887,408.3 мянган төгрөгийн олзыг валютын ханшийн зөрүүгээс бүрдүүлж, нийт 497,728,239.1 мянган төгрөг зарцуулан 243,188,323.5 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	373,701,070,884.87	285,390,681,167.17
1.1.3	Дансны авлага	47,685,035,980.09	52,217,325,742.11
1.1.4	Татвар, шимтгэлийн авлага	4,537,003,911.17	2,665,712,237.36
1.1.5	Бусад авлага	1,005,114,885.92	1,417,002,890.62
1.1.6	Бараа материал	219,319,588,089.23	180,738,727,114.61
1.1.7	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	68,825,671,911.73	28,497,255,335.46
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	17,967,142.86	22,158,809.46
1.1.9	Эргэлтийн хөрөнгийн дүн	715,091,452,805.87	550,948,863,296.79
1.2.1	Үндсэн хөрөнгө	26,577,999,980.90	23,798,617,083.30
1.2.2	Биет бус хөрөнгө	6,593,329,434.69	6,263,251,662.43
1.2.3	Биологийн хөрөнгө	43,707,142.86	41,066,190.40
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	434,179,457.49	434,179,457.49
1.2.5	Хойшлогдсон татварын хөрөнгө	3,325,464,613.89	2,097,083,224.87
1.2.6	Хайгуул үнэлгээний хөрөнгө	-	6,160,000,000.00
1.2.7	Бусад эргэлтийн бус хөрөнгө	31,358,326,886.15	28,368,832,545.15
1.2.7	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	68,333,007,515.98	67,163,030,163.64
1.3	ХӨРӨНГИЙН ДҮН	783,424,460,321.85	618,111,893,460.43
2.1.1	Дансны өглөг	18,074,449,920.88	63,657,643,883.65
2.1.2	Цалингийн өглөг	1,096,680,246.66	8,083.66
2.1.3	Татварын өр	22,573,244,443.95	54,733,810,295.80
2.1.4	НДШ-ийн өглөг	79,857,499.78	-
2.1.5	Ногдол ашгийн өглөг	658,515,350.94	658,515,350.94
2.1.6	Урьдчилж орсон орлого	202,309,176,909.15	181,081,296,251.39
2.1.7	Бусад богино хугацаат өр төлбөр	16,636,153,436.63	14,816,110,978.33
2.1.8	Богино хугацаат өр төлбөрийн дүн	261,428,077,807.99	314,947,384,843.78
2.2.1	Нөөц ба өр төлбөр	8,218,026,827.94	8,218,026,827.94
2.2.2	Хойшлогдсон татварын өр	4,451,524,250.96	7,261,085,649.60
2.2.3	Бусад урт хугацаат өр төлбөр	-	193,754,726.40
2.2.4	Урт хугацаат өр төлбөрийн дүн	12,669,551,078.90	15,672,867,203.94
2.2.5	Нийт өр төлбөрийн дүн	274,097,628,886.89	330,620,252,047.72
2.3.1	Өмч	94,487,644.09	94,487,644.09
2.3.3	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц	5,876,231,609.00	5,826,231,609.00
2.3.4	Хуримтлагдсан ашиг	503,356,112,181.87	281,570,922,159.62
2.3.5	Эздийн өмчийн дүн	509,326,831,434.96	287,491,641,412.71
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	783,424,460,321.85	618,111,893,460.43

Тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,158,398,002,569.03	727,400,236,142.93
2	Борлуулалтын өртөг	589,030,425,656.49	473,595,385,480.15
3	Нийт ашиг	569,367,576,912.54	253,804,850,662.78
4	Түрээсийн орлого	35,536,762.73	-
5	Хүүний орлого	4,146,634,873.50	2,520,816,659.19
7	Бусад орлого	2,583,139,636.12	108,101,436.83
8	Борлуулалт маркетингийн зардал	4,368,300,610.58	2,854,360,660.12
9	Ерөнхий ба удирдлагын зардал	16,575,572,532.76	16,977,851,552.67
10	Санхүүгийн зардал	-	-
11	Бусад зардал	2,711,170,054.27	4,244,031,156.32
12	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	(3,318,263,996.02)	10,887,408,324.79
13	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(56,610,216.52)
14	Татварын өмнөх ашиг	549,159,580,991.25	243,188,323,497.96
15	Орлогын татварын зардал	136,804,310,675.46	60,208,157,503.05
16	Тайлант жилийн ашиг	412,355,270,315.78	182,980,165,994.91

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Эздийн өмчийн дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	94,487,644.09	5,876,231,609.00	402,956,300,887.33	408,927,020,140.42
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(17,240,999,821.26)	(17,240,999,821.26)
Залруулсан үлдэгдэл	94,487,644.09	5,876,231,609.00	385,715,301,066.07	391,686,020,319.16
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	(294,714,459,200.00)	(294,714,459,200.00)
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	412,355,270,315.80	412,355,270,315.80
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	94,487,644.09	5,876,231,609.00	503,356,112,181.87	509,326,831,434.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(50,000,000.00)	(38,215,564,017.15)	(38,265,564,017.15)
Залруулсан үлдэгдэл	94,487,644.09	5,826,231,609.00	465,140,548,164.72	471,061,267,417.81
Зарласан ногдол ашиг	-	-	(366,549,792,000.01)	(366,549,792,000.01)
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	182,980,165,994.91	182,980,165,994.91
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	94,487,644.09	5,826,231,609.00	281,570,922,159.62	287,491,641,412.71

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого:	1,282,218,696,341.70	735,504,423,742.60
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,231,077,607,090.20	703,958,354,225.63
1.1.2	Буцаан авсан албан татвар	1,875,000,000.00	-
1.1.3	Бусад мөнгөн орлого	49,266,089,251.50	31,546,069,516.97
1.2	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага:	1,327,993,143,210.08	478,186,944,140.97
1.2.1	Ажиллагчдад төлсөн мөнгө	69,593,006,681.44	49,794,047,326.53
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	5,273,835,060.00	5,485,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	2,614,334,654.22	309,013,453,675.61
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	412,755,261.65	228,598,980.94
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	2,710,293,436.85	205,924,180.63
1.2.6	Төлсөн татвар	525,995,783,572.83	110,427,669,642.80
1.2.7	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	106,752,820.00	-
1.2.8	Бусад зардалд төлсөн мөнгө	721,286,381,723.09	3,032,250,334.46
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(45,774,446,868.38)	257,317,479,601.63
2.1.3	Хүлээн авсан хүүний орлого	6,944,385,376.17	2,257,694,607.15
2.2	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(5,943,910,902.39)	-
2.2.1	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	1,000,474,473.78	2,257,694,607.15
3.1.2	Төлсөн ногдол ашиг	(287,327,016,429.84)	(357,367,501,584.00)
3.1.3	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	(11,990,535.52)
3.1.4	Бусад	(4,722,302,173.75)	-
3.2	Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	(292,049,318,603.59)	(357,379,492,119.52)
3.3	Гадаад валютын ханшийн зөрүү	(7,904,253,059.71)	9,493,928,193.04
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(344,727,544,057.90)	(88,310,389,717.70)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	718,428,614,942.77	373,701,070,884.87
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	373,701,070,884.87	285,390,681,167.17

Тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

(мянган.төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны		
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /биетээр/						
1	Нүүрс олборлолт	Мянган төг	4,335.5	6,643.5	1,871.7	(4,771.8)
	Нүүрс борлуулалт	Мянган төг	2,714.4	7,607.3	2,283.0	(5,324.3)
	Үүнээс: Экспорт	Мянган төг	2,324.7	7,007.3	2,270.6	(4,736.7)
	Дотоод	Мянган төг	389.7	600.0	12.4	(587.6)
	Хөрс хуулалт	Мянган м3	24,027.6	36,717.3	11,593.6	(25,123.7)
	Нийт уулын цул	Мянган м3	27,613.1	41,462.6	12,931.1	(28,531.5)
2	Цэвэр борлуулалт	Мянган төг	1,158,398,002.6	2,513,302,807.8	727,400,236.1	(1,785,902,571.7)
	Хүүний орлого	Мянган төг	4,146,634.9	7,200,000.0	2,520,816.7	(4,679,183.3)
	Бусад орлого	Мянган төг	2,618,676.40	54,000.0	108,101.4	54,101.4
3	Нийт зардал	Мянган төг	616,003,732.9	1,452,200,101.0	497,671,628.9	(954,528,472.1)
	Үүнээс: а.Үндсэн үйлдвэрлэл	Мянган төг	589,030,425.6	1,416,456,079.7	473,595,385.5	(942,860,694.2)
	б. Ерөнхий ба удирдлагын зардал	Мянган төг	20,943,873.1	23,965,179.6	19,832,212.2	(4,132,967.4)
	в.Үйл ажиллагааны бус зардал	Мянган төг	6,029,434.2	11,778,841.7	4,244,031.2	(7,534,810.5)
	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	Мянган төг	(3,318,264.02)	-	10,887,408.32	-
	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	Мянган төг		-	(56,610.22)	-
4	Татвар төлөхийн өмнөх ашиг /ТТӨА/	Мянган төг	549,159,581.0	1,068,356,706.8	243,188,323.5	(825,168,383.4)
5	Цэвэр ашиг	Мянган төг	412,355,270.3	813,946,371.8	182,980,166.0	(630,966,205.8)
6	Төсөвт төлөх нийт төлбөр	Мянган төг	525,995,783.6	927,206,349.9	220,500,475.1	(706,705,874.8)
	Үүнээс: АМНАТөлбөр	Мянган төг	114,301,647.0	216,727,387.2	61,274,999.0	(155,452,388.2)
	Орлогын албан татвар	Мянган төг	136,804,310.7	254,410,335.0	60,208,157.5	(194,202,177.5)
	Бусад/9 төрөл/	Мянган төг	274,889,825.9	103,222,875.6	14,732,985.8	(88,489,889.8)
7	Ногдол ашиг хуваарилалт	Мянган төг	294,714,459.2	691,854,416.0	165,263,397.6	(526,591,018.4)
	Үүнээс: Орон нутаг	Мянган төг	150,304,374.2	352,845,752.2	84,284,332.8	(268,561,419.4)
	Бусад ХЭ	Мянган төг	144,410,085.0	339,008,663.8	80,979,064.8	(258,029,599.0)
8	Хөрөнгө оруулалт	Мянган төг	10,929,250.2	40,329,022.0	1,324,362.6	(39,004,659.4)
9	Нийт авлага	Мянган төг	53,227,154.80	-	56,300,040.9	-
	Үүнээс: Борлуулалтын авлага	Мянган төг	47,685,036.0	-	52,217,325.7	-
	Татвар шимтгэлийн авлага	Мянган төг	4,537,003.9	-	2,665,712.2	-
	Бусад авлага	Мянган төг	1,005,114.9	-	1,417,002.9	-
10	Нийт өр төлбөр	Мянган төг	274,097,628.9	-	330,620,252.0	-
	Богино хугацаат өр төлбөр	Мянган төг	261,428,077.8	-	314,947,384.8	-
	Урт хугацаат өр төлбөр	Мянган төг	12,669,551.1	-	15,672,867.2	-
11	Төлсөн татвар, хураамж нийт дүн	Мянган төг	525,995,783.6	927,206,349.9	220,117,821.8	(707,088,528.1)
12	Нийт ажиллагсдын тоо	Хүн	289	308	264	(44)
13	Нийт цалингийн сан	Мянган төг	24,727,055.3	34,270,338.5	24,065,225.1	(10,205,113.4)
14	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	0.53	0.58	0.68	0.10
15	1 тонн нүүрсний ашиг	төгрөг	151,912.3	106,995.62	80,147.6	(26,848.0)
16	Ашгийн хувь	хувь	35.6%	32.4%	25.2%	(7.2%)
17	Хөрс хуулалтын коэффициент	м3/тонн	5.5	5.5	6.2	0.7

3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 30,021,856.7 мянган төгрөгийн 16 зөрчлөөс 699,975.8 мянган төгрөгийн 4 зөрчил нь өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүнгээр тайлант оны алдаа зөрчлөөр нэмэгдэн орж ирсэн.

Нийт 30,021,856.7 мянган төгрөгийн нийцлийн асуудлаар илэрсэн зөрчлөөс 7,949,691.5 мянган төгрөгийн 10 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 22,072,165.2 мянган төгрөгийн 6 зөрчилд зөвлөмжийг өглөө.

3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх ёстой мэдээллийг цаг тухайд оруулсан байна.

3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Дараах нийт 7,249,715.7 мянган төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт-1: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй шууд худалдан авалтаар нийт 796,001.6 мянган төгрөгийн төмөр замын гармын төлбөр, чингэлэг тээврийн терминалын үйлчилгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан боловч тендер зарлаагүй шууд худалдан авсан 5,564,983.0 мянган төгрөгийн нүүрс ачиж буулгах талбайн түрээс, түлш шатахуун, харуул хамгаалалт, машин тоног төхөөрөмжийн сэлбэг, тавилга эд хогшил, хурлын тоног төхөөрөмж, кондейшн, программ хангамж, компанийн “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам”-ыг баримтлаагүй 87,994.1 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т *“Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна”*, 40 дүгээр зүйлийн 40.2.1-т *“Энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно”*, 44 дүгээр зүйлийн 44.1-т *“Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”*, Гүйцэтгэх захирлын 2025 оны А/023 дугаар тушаалаар баталсан “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4.1-т *“Бараа, ажил үйлчилгээ худалдан авах зарыг компанийн цахим хуудаст ажлын 3 өдөр байршуулах”*, 4.4.3 *“Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зарын дагуу үнийн санал ирээгүй тохиолдолд үнийн саналын харьцуулсан судалгаа хийж, Худалдан авалт, хангамж хариуцсан хэлтсийн удирдлагад танилцуулан шууд худалдана авах”*, журмын нэгдүгээр хавсралт *“Төсөвт тусгагдсан эсэх, тусгагдсан тохиолдолд төсвийн үлдэгдэл, нэршил, тоо хэмжээ, мөнгөн урсгалын төсөөллийг хянах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт-2: Ковшийн хөдөлгүүрийн сэлбэг худалдан авах, их засварын ажлын 62,488.2 мянган төгрөгийн шууд худалдан авалтыг өөр албан ёсны эрхтэй нийлүүлэгч байхгүйг нотлох анхан шатны баримтгүй ажил гүйлгээ санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 48 дугаар зүйлийн 48.4.2-д "нээлттэй тендер шалгаруулалтын аргаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгох болсон үндэслэлийг тендер шалгаруулалтын баримт бичигт хавсаргана" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт-3: Гүйцэтгэх захирлын 2025 оны А/023 дугаар тушаалаар баталсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын 5 дугаар зүйлийн 5.7-д "Үнэлгээний хороо нь хуралдаанаа цахим хэлбэрээр зохион байгуулж болох бөгөөд архив, бичиг хэргийн стандартын дагуу үнэлгээний хорооны зөвлөмж, хуралдааны тэмдэглэл болон холбогдох баримт бичгийг цаасан хэлбэрээр баталгаажуулж ажиллана" гэж тусгасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.5-д "Хууль тогтоомжид заасан үндэслэлээр эрх бүхий байгууллагаас тогтоосон бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон болон түүнтэй адилтгах бусад нөхцөл байдлаас шалтгаалан хуралд үнэлгээний хорооны бүх, эсхүл зарим гишүүд биечлэн оролцох боломжгүй бол тухайн гишүүдийг хуралд цахим хэлбэрээр оролцуулж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт-4: Тендерийн бичиг баримтад тусгасан хүний нөөцийн шаардлага, ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын нотлох баримт дутуу оролцогчийг сонгон шалгаруулан Цогтцэций суманд 40 га-д худаг барих, хөрөнгийн үнэлгээ хийх нийт 158,843.2 мянган төгрөгийн ажил гүйцэтгүүлсэн мөн худалдан авах тоо, хэмжээ, үнийг тендерийн нийт өртөгтэй уялдуулаагүйгээс 267,198.0 мянган төгрөгийн АИ-92 бензин болон 156,816.0 мянган төгрөгийн тос, тослох материал худалдан авах тендерүүд тус тус хүчингүй болсон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5-д "Оролцогчийн чадавхын болон туршлагын мэдээлэл төрийн эрх бүхий байгууллагад тайлагнаж баталгаажсан санхүү, нийгмийн даатгалын тайлангийн мэдээлэлтэй нийцсэн эсэхийг хянан үзэж болно", Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 19.1-д "мэргэшсэн үнэлгээчин 1, тэргүүлэх үнэлгээчин 1, үнэлгээчин 2, туслах 1 байх, тэргүүлэх үнэлгээчин, хугацаагүй эрхтэй үнэлгээчин, сүүлийн 6 сар, үнэлгээчин, туслах ажилтан нь сүүлийн 1 жил тухайн байгууллагад ажилласан", тендер шалгаруулалтын зааварчилгааны 19.1-т "Өрмийн туслах 4 байх, 3-с доошгүй сар тухайн байгууллагад ажилласан, мэргэжлээрээ 2-с дээш жил ажилласан туршлагаатай", Тендерийн баримт бичгийн гэрээний тусгай нөхцөлийн 5.6-д "тухайн гүйцэтгэх ажлын 50% гүйцэтгэлийн акт үйлдэгдэж, захиалагчаар баталгаажсаны дараа нэхэмжлэхийг үндэслэж, үлдэгдлийг 100% гүйцэтгэлд акт, худгийн гэрчилгээг үндэслэж шилжүүлнэ", 4.9-д "ажил эхэлсэн өдрөөс хойш 60 хоногт багтаан дуусгах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт-5: Гүйцэтгэх захирлын А/013, А/022 дугаар тушаалуудаар аж ахуйн нэгж байгууллагуудаас авах авлага барагдуулах 2 удаагийн ажлын хэсэг байгуулан ажилласан боловч ажлын үр дүнг хэлэлцээгүй, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар биелэгдээгүй, тушаалын хэрэгжилт хангагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй байна.

Илрүүлэлт-6: Өмгөөллийн чиглэлээр нэг төрлийн үйлчилгээ авахдаа сонгон шалгаруулалтгүй шууд гэрээ байгуулж 57,000.0 мянган төгрөгийн үйлчилгээ авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй байна.

Дараах нийт 22,072,165.2 мянган төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өглөө.

Илрүүлэлт-1: Тайлант оны эхний 8-н сар олборлолт хийгээгүй компанийн үндсэн үйл ажиллагаа нь зогсонги байсан ч бодит нөхцөлтэй уялдуулан бизнес төлөвлөгөө болон худалдан авах ажиллагаа /ХАА/-ны төлөвлөгөөнд өөрчлөлт, тодотгол хийгээгүй. Компанийн бизнес төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүд нь тодорхой бус нэгтгэгдсэн мөн батлагдсан бизнес төлөвлөгөөтэй уялдаагүй бараа ажил, үйлчилгээг ХАА-ны төлөвлөгөөнд тусгасан байна

Өгсөн зөвлөмж. Компанийн үйл ажиллагааны нөхцөл байдлаас хамаарч материаллаг хэмжээний өөрчлөлт орсон нөхцөлд бизнес төлөвлөгөөний тодотгол хийх, бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, худалдан авалтаар худалдан авалтын төлөвлөгөөг батлан, мөрдөж ажиллах

Илрүүлэлт-2: Тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээний дагуу сар бүр гэрээний 8.5 дах заалтад "Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлыг сар бүр гаргаж, хасагдах оноо тус бүрийг тухайн сард гүйцэтгэх төлөвлөгөөт тэсэлгээний ажлын мөнгөн дүнгийн 0.01%-р үржүүлэн гүйцэтгэгчид төлөх нийт төлбөрөөс хасаж тооцно гэж заасан бол уг гэрээний хавсралт-3-ын 3.3-д KPI үнэлгээнээс хамаарч 0.01%-0.05% хүртэл үржүүлж хасна гэсэн заасан байна. Компани гэрээний 8.5 заалтаа барьж тэсэлгээний ажлын төлбөрийг тооцоолж байгаа хэдий ч төлбөрөөс хасах дүнг тооцоолох 2 өөр хувилбар гэрээнд тусгагдсан байна.

Өгсөн зөвлөмж.: Тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээний KPI хамаарч төлбөрөөс суутган хасах төлбөрийг гэрээнд өөр өөр хувилбараар тусгасныг өөрчилж, гэрээнд өөрчлөлт оруулах

Илрүүлэлт-3: Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг сүүлийн 3 жилээр харьцуулан дүн шинжилгээ хийхэд хэрэгжилт дунджаар 33.0 хувьтай байна.

Өгсөн зөвлөмж.: Бизнес төлөвлөгөөний хэрэгжилт, хэрэгжихгүй байгаа шалтгаан, үр дагавар, төлөвлөлтийн оновчтой байдал зэрэгт компанийн эрх бүхий албан тушаалтнуудын зүгээс хяналт тавьж ажиллах

Илрүүлэлт-4: Компанийн урт хугацааны стратеги төлөвлөгөө болон дунд хугацааны төлөвлөгөө байхгүй, компанийн хэтийн зорилго, зорилт тодорхой бус байгаа нь бизнесийн төлөвлөгөө бодитой боловсруулагдах, биелэлт хангалтгүй байх үндэс суурь болж байна.

Өгсөн зөвлөмж.: Компанийн стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулж, дагаж мөрдөх

Илрүүлэлт-5: Цогтцэций суманд 40 га-д байгуулах Худгийн ажлын даалгаврыг байгаль орчны ахлах мэргэжилтэн боловсруулж, хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн хянаж, Уул уурхайн технологийн газрын захирал зөвшөөрсөн боловч гарын үсэггүй Гүйцэтгэх захирал баталсан байна.

Өгсөн зөвлөмж.: Ажлын даалгавар боловсруулалтыг хуулийн хүрээнд боловсруулах

Илрүүлэлт-6: Тээвэр болон борлуулалттай холбоотой гэрээний үүргийн биелэлтийг тухай бүр нь дүгнэж, тооцоо нийлсэн актыг үйлдэж хариуцсан мэргэжилтэн нь цаг тухай бүрд нягтлан болох бүртгэлийн хэлтэст танилцуулахгүй байгаатай холбоотой он дамжсан гэрээний төлбөр үүссэн, цаашид нэмж үүсэх эрсдэлийг бий болгож байна.

Өгсөн зөвлөмж: Тээвэр болон борлуулалттай холбоотой гэрээний үүргийн биелэлтийг гэрээний үнийн дүн, тоо хэмжээгээр хийж, тооцоо нийлсэн актыг үйлдэх, нэгж хэлтсүүдийн уялдаа холбоог сайжруулах, нүүрсний хөдөлгөөнийг бүртгэх журам боловсруулан мөрдөх

4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21,979,134.3 мянган төгрөгийн нийт 16 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

1. Ханшийн тэгшитгэлийг алдаатай бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх" 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг,

2. Бараа материалын хөдөлгөөнийг 1,447,970.1 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг,

3. АБТ-ын талбайн үлдэгдлээр НАБТ-ын түрээсийн зардлыг 52,866.9 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө" 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг,

4. Өмнөговь аймгийн Ханбогд суманд байршилтай 4601021296 нэгж талбарын дугаар бүхий Гаалийн хяналтын талбай зориулалтаар ашиглах газар эзэмших эрхийг 2023.12.31 өдөр 50,000.0 мянган төгрөгөөр санхүү бүртгэлд давхардуулан бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт, хэмжилт ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг,

5. Уурхайн хөрөнгө ТЭЗҮ-д хорогдлыг 69,368.0 мянган төгрөгөөр илүү тооцсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг

баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалт, хэмжилт ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг,

6. Хайгуул ба үнэлгээний 2,960,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг ТЭЗҮ-гээр бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалт, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг,

7. Экспортод гаргаж буй нүүрсний борлуулалтын бүртгэлийг санхүү бүртгэлд бүртгэхдээ 89,707.2 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалт, хэмжилт ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг,

8. Гаалийн бүрдүүлэлтийн зардал 315,936.3 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалт, хэмжилт ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг,

9. Хүний нөөц, диспетчерийн программ хөгжүүлэлттэй холбоотой 66,000.0 мянган төгрөгийн урьдчилгааг тайлант үеийн зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг,

10. Компанийн үндсэн үйл ажиллагаа зогсож ажилчдад олгосон 3,263,522.7 мянган төгрөгийн сул зогсолтын олговор, түүнд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг ерөнхий удирдлагын зардлын бусад зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалт, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг,

11. Бласт ХХК-ийн KPI суутгалыг 5,554.5 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн

стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг,

12. Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн 2025 оны 4-р сарын 08-ны өдрийн №144/ШШ2025/00095 тоот шийдвэрээр нэхэмжилсэн 2024 оны үр дүнгийн урамшуулалт цалин 21,445.3 мянган төгрөгийг хүчингүй болгосон хэдий ч олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт, хэмжилт ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг,

13. Шүүхийн шийдвэртэй нэхэмжлэгчид төлсөн төлбөрийг буруутай этгээдээр төлүүлэлгүй компаниас 266,186.9 мянган төгрөгийг төлсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт, хэмжилт ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг,

14. 47-47 ӨМА улсын дугаартай тээврийн хэрэгсэлд хийсэн моторын засварын 27,780.0 мянган төгрөгийн зардлыг хөрөнгийн өртөгт капиталжуулаагүй тайлант хугацааны засварын зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг,

15. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өглөгийн үлдэгдлийг татварын цахим системийн үлдэгдэл, татварын төлөлт, нэхэмжлэл рүү тулган шалгахад 2024 онд төлсөн татварын акт болон аудитын залруулгыг ногдуулалтыг дутуу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт, хэмжилт ба тохиолдсон байх батламж мэдэгдлийг,

16. Тайлант жилийн татварын зардал, хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг 4,344,970.5 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт 39,303,613.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 38,678,789.0 мянган төгрөгийн зөрчилд 14 албан шаардлага, 624,824.8 мянган төгрөгийн зөрчилд 10 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 39,303,613.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 31,894,537.3 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө

4.1 Албан шаардлага

Илрүүлэлт-1: Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр бүхий 3 гишүүнд тус бүр 73,000.0 мянган төгрөгийн эмчилгээний зардал, байгууллагын 8 ажилтанд тус бүр 8,000.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, сургалтын төлбөр, хэвлэл мэдээллийн үйлчилгээний төлбөрт 36,000.0 мянган төгрөг нийт 319,000.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д “анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоо”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцээгүй байна

Илрүүлэлт-2: Тайлант онд Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн №144/ШШ2025/00046 дугаар шийдвэрээр 81,441.6 мянга, №144/ШШ2025/00014 дугаар шийдвэрээр 67,608.6 мянга, №144/ШШ2025/00095 дугаар шийдвэрээр 75,058.3 мянга, №144/ШШ2024/00168 дугаар шийдвэрээр 63,523.5 мянга нийт 287,632.2 мянган төгрөгийн хохирлыг нэхэмжлэгчдэд компаниас төлж барагдуулсан бөгөөд төлбөрийг гэм буруутай этгээдээр буцаан төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасантай нийцээгүй байна.

Илрүүлэлт-3: Тайлант хугацаанд хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, байнгын ажлын байрны орон тоонд ажиллаагүй ажилтанд 2024, 2025 онуудын амралтын хугацааны цалин, үр дүнгийн урамшуулал болон бусад нэмэгдэлд нийт 67,639.7 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.15-д “Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа гэж ажилтан нь ажил олгогчийн удирдлага, заавар, хяналтын доор тодорхой ажил үүргийг энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд ажил олгогчийн заасан ажлын байранд биечлэн гүйцэтгэх, ажил олгогч нь ажилтанд цалин хөлс олгох, хөдөлмөр эрхлэлтийн бусад нөхцөлөөр хангах талаар харилцан эрх эдэлж, үүрэг хүлээхээр тохиролцсоноор үүссэн харилцааг”, 47 дугаар зүйлийн 47.1-д “Ажил олгогч, ажилтан харилцан тохиролцож, хөдөлмөрийн гэрээ байгуулна”, 48 дугаар зүйлийн 48.2-д “Хүндэтгэн үзэх шалтгаанаар хөдөлмөрийн гэрээг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр үйлдээгүй бол ажилтныг ажил үүргээ гүйцэтгэж эхэлснээс хойш ажил олгогч ажлын 10 өдрийн дотор хөдөлмөрийн гэрээг нөхөн байгуулах үүрэгтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасан заалттай тус тус нийцээгүй байна.

Илрүүлэлт-4: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн төлөөлөл болох албан хаагчдад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс илүү үндсэн

цалин болон үр дүнгийн урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд нийт 241,624.2 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12-д "төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно", Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2023-2024 оны хамтын хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 3.2-д "геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна", Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор баталсан "төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх тухай" журмын 7 дугаар зүйлийн 7.2-д "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үндсэн цалингийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлснээс ихгүй байх бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороонд ажилласан байдлыг харгалзан нэмэгдэл олгож болно. Нэмэгдлийн хэмжээ үндсэн цалингийн хэмжээний дөрөвний нэгээс хэтрэхгүй байна", мөн 7.7-д "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ журамд заасан цалин хөлснөөс бусад баталгаа, хангамж эдлэхийг хориглоно", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.9-д "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрд ногдох хувийг эзэмшигчийн төлөөлөгч албан тушаалтан нь тухайн хуулийн этгээдэд ажиллах хугацаандаа, түүнчлэн албан үүргээ гүйцэтгэж дууссанаас хойш хоёр жилийн хугацаанд тухайн хуулийн этгээд, түүний удирдлагын гишүүдээс бэлэг авахыг хориглоно" мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "бэлэг" гэж нийтийн албан тушаалтанд үнэ төлбөргүй эд хөрөнгө өгөх, үйлчилгээ үзүүлэх болон эрх шилжүүлэх, үүргээс чөлөөлөх, нийтийн албан тушаалтантай хамаарал бүхий этгээдийн тусын тулд эрхээс татгалзах зэрэг бусад хэлбэрийн санхүүгийн үр ашгийг" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Илрүүлэлт-5: Гүйцэтгэх захирлын тушаалаар ажилтнуудад мэргэшсэн эрхийн нэмэгдлийн хувийг ялгаатай тогтоон 2,248.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1-д "ажилтны ур чадварын, ажилласан жилийн, мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласны болон бусад нэмэгдлийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно" гэж заасантай нийцээгүй байна.

Илрүүлэлт-6: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 07 дугаар тогтоол, Гүйцэтгэх захирлын 2025 оны А/056 дугаар "Үр дүнгийн урамшуулал олгох тухай" тушаалаар нийт ажилтнуудад 2024 оны 6 хүртэлх сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгохдоо тус онд бүтэн ажиллаагүй хүүхдээ асрах чөлөөтэй байгаа эхчүүд, ажлаас чөлөөлөгдсөн болон туршилтын хугацаанд ажиллаж байсан ажилтнуудад ажилласан хугацаанд ногдохоор тооцож олгоогүй, ашигт ажиллагааны түвшнийг тогтоох болон олгох журамгүй, мөн ашигт ажиллагааны урамшууллыг үр дүнгийн урамшуулал нэрээр олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нээж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай нийцээгүй байна.

Илрүүлэлт-7: Тайлант онд компанийн гүйцэтгэх захирлын 50 насны тэгш ойд нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний 14,000.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь "Тавантолгой" ХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороо хоорондын хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.14-д "хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх хэсгийг үндэслэн компанид 10 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа ахмад

ажилтны 50, 60-н насны тэгш ойг нь тохиолдуулан сарын үндсэн цалингаар тооцож урамшууллыг нэг удаа олгоно" гэж заасантай нийцээгүй байна.

Илрүүлэлт-8: Санхүү байдлын тайланд тусгасан нийт авлагын 33.9 хувь, урьдчилж орсон орлогын 4.9 хувь буюу нийт 31,258,446.6 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй байна.

Илрүүлэлт-9: Дараа тайлангийн урьдчилгаа, урьдчилж төлсөн тооцоо дансанд сүүлийн 2 жил хөдөлгөөн ороогүй 903,371.9 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй байна.

Илрүүлэлт-10: Засвар механикийн албаны GPS-тэй автомашины шатахууны тайлан нярвын олгосон шатахуун бүртгэлээс 7,315 литр буюу 22,457.0 мянган төгрөгөөр илүү байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцээгүй байна.

Илрүүлэлт-11: Тэтгэвэрт гарсан ажилтны хүний нөөцийн алдаатай мэдээллээс ажилласан жилийг ялгаатай тооцсоны улмаас 105,771.9 мянган төгрөгийн тэтгэмжийг зөрүүтэй олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцээгүй байна.

Илрүүлэлт-12: ТТОВА/2023/009 тоот гэрээтэй Urad middle banner huijia trading компанид гаалийн мэдээ болон цахим тайлангийн системийн (e tax) мэдээгээр 96,110.7 тонн нүүрс нийлүүлсэн бөгөөд худалдан авагч тал үүнээс 6,377.25 тонн нүүрсийг хүлээн аваагүй гэдэг тайлбартайгаар тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй байна.

Илрүүлэлт-13: Тайлант онд байгуулсан ТТОВА/2025/005, ТТОВА/2025/009, ТТОВА/2025/011, ТТОВА/2025/013 дугаартай нүүрс нийлүүлэх гэрээнүүдийн дагуу 288,000.00 тонн нүүрсийг

уурхайгаас нүүрс ачиж буулгах талбай руу ачуулах ёстой хэдий ч уурхайгаас ачигдаж буй нүүрсний тоо хэмжээнд тавих дотоод хяналт хангалтгүйн улмаас 3,977.7 тонн нүүрс илүү ачигдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай нийцээгүй байна

Илрүүлэлт-14: "Смарт эко транс" ХХК-ийн AGV буюу Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал дахь нүүрсний хөдөлгөөний мэдээ, борлуулалт тээврийн хэлтсийн борлуулалтын мэдээнээс 1,088.7 тонн буюу 110,120.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцээгүй байна.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт-1: Компанийн 2025 оны 12-р сарын 31-ны өдрөөрх сэлбэгийн үлдэгдэлд шинжилгээ хийхэд сүүлийн 2 жил хөдөлгөөнд ороогүй 364 нэр төрлийн 4,226 ширхэг 444,016.8 мянган төгрөгийн сэлбэгийн үлдэгдэл байна.

Өгсөн зөвлөмж: Компани нь техник, машин механизмд шаардлагатай сэлбэгийн нөөцийг бүрдүүлэх журмыг батлан дагаж мөрдөх, сэлбэгийн худалдан авалтад хийж буй дотоод хяналтыг сайжруулах, цаашид ашиглах боломжгүй сэлбэгийг актлах, борлуулах хэлбэрээр эргэлтэд оруулах

Илрүүлэлт-2: Биржийн арилжаанд ялсан харилцагчийн Монголын Хөрөнгийн биржид байршуулсан дэнчингийн тооцоог компани санхүү бүртгэлд тусгаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Монголын Хөрөнгийн биржид байршуулсан дэнчинг тооцоо нийлж, санхүүгийн бүртгэлд тусгах

Илрүүлэлт-3: Таван толгой ХК-ийн нүүрсний биржийн арилжаанд тогтоосон үнийг зах зээл дээр ижил төрлийн нүүрс арилжаалж буй Эрдэнэс таван толгой ХК-ийн арилжааны үнэтэй харьцуулахад Эрдэнэс таван толгойн дуудах үнээс доогуур үнээр хэлцэл хийсэн байгаа бөгөөд энэ нь борлуулалтын орлого, ашигт ажиллагаа буурах эрсдэлтэй байна.

Өгсөн зөвлөмж: Бирж дээр дуудах үнийг тогтоох процесс горимд тавих хяналтыг сайжруулах, ажил үүргийн хуваарилалтыг хяналттай байхаар тодорхойлох.

Илрүүлэлт-4: Нэр бүхий 6 компанийн нүүрс буулгах талбайд 2023-2024 онд буулгасан 247.9 мянган тонн нүүрс байна. Тухайлбал Ногоолин хэрлэн ХХК-ийн талбайд 2023/007 гэрээний 57.8 мянган тонн, Энхдэлгэр говь ХХК-ийн талбайд 2023/005 гэрээний 0.8 мянган тонн, 2024/008 гэрээний 0.1 мянган тонн, Тахидаг хайрхан ХХК-ийн талбайд 2024/016 гэрээний 2.2 мянган тонн, 2024/017 тоот гэрээний 32.4 мянган тонн, Ёл ресурс ХХК-ийн талбайд 2024/007 гэрээний 57.7 мянган тонн, 2024/017 гэрээний 25.1 мянган тонн, Эрхэм сүлд монгол ХХК-ийн 2023/005 гэрээний 0.2 мянган тонн, 2023/009 гэрээний 25.0 мянган тонн, 2023/017 гэрээний 32.1 мянган тонн, 2024/010 гэрээний 0.3 мянган тонн, 2024/016 гэрээний 14.1 мянган тонн нүүрс тус тус байна

Өгсөн зөвлөмж: НАБТ үлдэгдэлтэй байгаа нүүрсний чанар байдлыг тодорхойлон, чанарт нөлөө үзүүлэхүйц байвал бараа материалын үнэ цэний бууралтыг тооцож, санхүүгийн тайланд тусгах

Илрүүлэлт-5: Бараа материалын жилийн эцсийн тооллогод хяналтаар оролцон 21 нэр төрлийн 966 ширхэг 450,643.5 мянган төгрөгийн сэлбэг тоолоход 1 нэр төрлийн 25 ширхэг 7,690.08 мянган төгрөгийн сэлбэг тухайн үед дутуу байсан ба маргааш өдөр нь дутуу сэлбэгийг видео дуудлага хийн тоолуулсан. Компанийн агуулах дахь бараа материалын байрлал, тэмдэглэгээ тодорхойгүй, зохион байгуулалт, эмх цэгц маш хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сэлбэгийн агуулахын эмх цэгцийг бүрдүүлэх, бараа материалын тооллогыг чанартай үр дүнтэй хийх

Илрүүлэлт-6: Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг тухайн хөрөнгийн эдийн засгийн насаар бус татварын хуульд тусгагдсан жилээр элэгдүүлж байгаа нь үндсэн хөрөнгийн стандарттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг тухайн хөрөнгийн эдийн засгийн насаар тооцоолж, ашиглалтын хугацаанд жил бүр хяналт хийх

Илрүүлэлт-7: Хөрөнгийн хуучралт, элэгдэл эсвэл биет эвдрэл гэмтэл, хүрээлэн буй орчин эдийн засаг, зах зээл, технологийн хоцрогдол зэргийг үндэслэн үндсэн хөрөнгийн дансанд үнэ цэний бууралтын тооцоолол хийгээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн шинж байдлаас хамаарч үнэ цэний бууралтын тооцооллыг хийж, үндсэн хөрөнгийн өртгийг жил бүр хянах

Илрүүлэлт-8: Ford 5588 ӨМЭ суудлын автомашин нь компанийн эзэмшлийнх биш хэдий ч авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн лавлагаанд бүртгэлтэй хэвээр байна

Өгсөн зөвлөмж: Ford 5588 ӨМЭ суудлын автомашиныг ч авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлээс хасуулах

Илрүүлэлт-9: Компани нь эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээх хуулийн эсвэл үүсмэл өнөөгийн үүрэг хариуцлага хүлээж байгаа ч тайлант онд уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн нөөц болон холбогдох хөрөнгийн бүртгэлийг НББОУС-ын дагуу тооцон бүртгээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн нөөц болон холбогдох хөрөнгийн бүртгэлийг НББОУС-ын дагуу тооцон бүртгэх журмыг боловсруулан дагаж мөрдөх

Илрүүлэлт-10: Байгууллага нь СТОУТХ 20-д тусгагдсан хөрс хуулалтын зардлыг хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх үндсэн 3-н шалгуур үзүүлэлтийг зэрэг хангаагүйгээс ил уурхайн олборлолт болон үйлдвэрлэлийн шатанд хуримтлагдах уурхайн хаягдал зайлуулах (хөрс хуулалтын) зардлуудыг стандартын дагуу бүртгээгүй буюу бүртгэх боломжгүй байна.

Өгсөн зөвлөмж: СТОУТХ 20-д тусгагдсан хөрс хуулалтын зардлыг хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх журмыг боловсруулан дагаж мөрдөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

(мянган төгрөгөөр)

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Ханшийн тэгшитгэлийг алдаатай бүртгэсэн.	1	1,582.6	-	-	1	1,582.6	1	1,582.6	-	-	-	-
2	Бараа материалын хөдөлгөөнийг дутуу бүртгэсэн.	1	1,447,970.1	1	1,447,970.1	-	-	1	1,447,970.1	-	-	-	-
3	НАБТ-ын талбайн үлдэгдлээр НАБТ-ын түрээсийн зардлыг дутуу бүртгэсэн.	1	52,866.9	1	52,866.9	-	-	1	52,866.9	-	-	-	-
4	Өмнөговь аймгийн Ханбогд суманд байршилтай 4601021296 нэгж талбарын дугаар бүхий Гаалийн хяналтын талбай зориулалтаар ашиглах газар эзэмших эрхийг санхүү бүртгэлд давхардуулан бүртгэсэн байна.	1	50,000.0	-	-	1	50,000.0	1	50,000.0	-	-	-	-
5	Уурхайн хөрөнгө ТЭЗҮ-д хорогдол тооцсон	1	69,368.0	-	-	1	69,368.0	1	69,368.0	-	-	-	-
6	Хайгуул ба үнэлгээний хөрөнгийг ТЭЗҮ-гээр бүртгэсэн.	1	2,960,000.0	-	-	1	2,960,000.0	1	2,960,000.0	-	-	-	-
7	Экспортод гаргаж буй нүүрсний борлуулалтын бүртгэлийг санхүү бүртгэлд бүртгэхдээ буруу бүртгэсэн.	1	89,707.2	-	-	1	89,707.2	1	89,707.2	-	-	-	-
8	Гаалийн бүрдүүлэлтийн зардал дутуу бүртгэсэн	1	315,936.3	-	-	1	315,936.3	1	315,936.3	-	-	-	-
9	Хүний нөөц, диспетчерийн программ хөгжүүлэлттэй холбоотой урьдчилгаа төлбөрийг тайлант үеийн зардлаар бүртгэсэн.	1	66,000.0	-	-	1	66,000.0	1	66,000.0	-	-	-	-
10	Компанийн үндсэн үйл ажиллагаа зогсож ажилчдад олгосон сул зогсолтын олговор, түүнд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг ерөнхий удирдлагын зардлын бусад зардалд бүртгэсэн.	1	3,263,522.7	-	-	1	3,263,522.7	1	3,263,522.7	-	-	-	-
11	Бласт ХХК-ийн KPI суутгалыг илүү бүртгэсэн.	1	5,554.5	-	-	1	5,554.5	1	5,554.5	-	-	-	-

Тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

12	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн 2025 оны 4-р сарын 08-ны өдрийн №144/ШШ2025/00095 тоот шийдвэрээр нэхэмжилсэн 2024 оны үр дүнгийн урамшуулалт цалин 21,445.3 мянган төгрөгийг хүчингүй болгосон хэдий ч олгосон байна.	1	21,445.3	-	-	1	21,445.3	1	21,445.3	-	-	-	-
13	ШШД нэхэмжлэгчид төлсөн төлбөрийг буруутай этгээдээр төлүүлэлгүй компаниас төлсөн	1	266,186.9	-	-	1	266,186.9	1	266,186.9	-	-	-	-
14	47-47 ӨМА улсын дугаартай тээврийн хэрэгсэлд хийсэн моторын засварын зардлыг хөрөнгийн өртөгт капиталжуулаагүй тайлант хугацааны засварын зардлаар бүртгэсэн	1	30,209.6	-	-	1	30,209.6	1	30,209.6	-	-	-	-
15	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 2024 онд төлсөн татварын акт болон аудитын залруулгын ногдуулалтыг дутуу бүртгэсэн байна.	1	8,993,813.7	1	8,993,813.7	-	-	1	8,993,813.7	-	-	-	-
16	Тайлант жилийн татварын зардал, хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг дутуу бүртгэсэн	1	4,344,970.5	1	4,344,970.5	-	-	1	4,344,970.5	-	-	-	-
Нийт дүн		16	21,979,134.3	4	14,839,621.2	12	7,139,513.1	16	21,979,134.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн		
1	Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр бүхий 3 гишүүнд тус бүр 73,000.0 мянган төгрөгийн эмчилгээний зардал, байгууллагын 8 ажилтанд тус бүр 8,000.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, сургалтын төлбөр, хэвлэл мэдээллийн үйлчилгээний төлбөрт 36,000.0 мянган төгрөг нийт 319,000.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй олгосон байна.	1	319,000.0			1	319,000.0								

Тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2	Тайлант онд Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн №144/ШШ2025/00046 дугаартай, №144/ШШ2025/00014 дугаартай, №144/ШШ2025/00095 дугаартай, №144/ШШ2024/00168 дугаартай шийдвэрүүдийн хохирлыг нэхэмжлэгчдэд компаниас төлж барагдуулсан бөгөөд төлбөрийг гэм буруутай этгээдээр буцаан төлүүлээгүй байна	1	287,632.2			1	287,632.2						
3	Тайлант хугацаанд хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, байнгын ажлын байрны орон тоонд ажиллаагүй ажилтанд 2024, 2025 онуудын амралтын хугацааны цалин, үр дүнгийн урамшуулал болон бусад нэмэгдэл олгосон байна.	1	67,639.7			1	67,639.7						
4	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн төлөөлөл болох албан хаагчдад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс илүү үндсэн цалин болон үр дүнгийн урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд нийт 241,624.2 мянган төгрөг зарцуулсан байна	1	241,624.2			1	241,624.2						
5	Гүйцэтгэх захирлын тушаалаар ажилтнуудад мэргэшсэн эрхийн нэмэгдлийн хувийг ялгаатай тогтоон олгосон байна.	1	2,248.0			1	2,248.0						
6	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 07 дугаар тогтоол, Гүйцэтгэх захирлын 2025 оны А/056 дугаар "Үр дүнгийн урамшуулал олгох тухай" тушаалаар нийт ажилтнуудад 2024 оны 6 хүртэлх сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгохдоо тус онд бүтэн ажиллаагүй хүүхдээ асрах чөлөөтэй байгаа эхчүүд, ажлаас чөлөөлөгдсөн болон туршилтын хугацаанд ажиллаж байсан ажилтнуудад ажилласан хугацаанд ногдохоор тооцож олгоогүй, ашигт ажиллагааны түвшнийг тогтоох болон олгох журамгүй, мөн ашигт ажиллагааны урамшууллыг үр дүнгийн урамшуулал нэрээр олгосон байна.	1	-			1	-						
7	Тайлант онд компанийн гүйцэтгэх захирлын 50 насны тэгш ойд нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгосон байна.	1	14,000.0			1	14,000.0						
8	Санхүү байдлын тайланд тусгасан нийт авлагын 33.9 хувийг, урьдчилж орсон орлогын 4.9 хувийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	31,258,446.6			1	31,258,446.6						

Тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

9	Дараа тайлангийн урьдчилгаа, урьдчилж төлсөн тооцоо дансанд сүүлийн 2 жил хөдөлгөөн ороогүй 903,371.9 мянган төгрөгийн үлдэгдэл байна.	1	903,371.9			1	903,371.9						
10	Засвар механикийн албаны GPS-тэй автомашины шатахууны тайлан нярвын олгосон шатахуун бүртгэлээс 7,315 литр буюу 22,457.0 мянган төгрөгөөр илүү байна.	1	22,457.0			1	22,457.0						
11	Тэтгэвэрт гарсан ажилтны хүний нөөцийн алдаатай мэдээллээс ажилласан жилийг ялгаатай тооцсоны улмаас 105,771.9 мянган төгрөгийн тэтгэмжийг зөрүүтэй олгосон байна	1	105,771.9			1	105,771.9						
12	ТТОВА/2023/009 тоот гэрээтэй Urad middle banner huijia trading компанид гаалийн мэдээ болон цахим тайлангийн системийн (e tax) мэдээгээр 96,110.7 тонн нүүрс нийлүүлсэн бөгөөд худалдан авагч тал үүнээс 6,377.25 тонн нүүрсийг хүлээн аваагүй гэдэг тайлбартайгаар тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	3,932,328.1			1	3,932,328.1				1	-	
13	Тайлант онд байгуулсан ТТОВА/2025/005, ТТОВА/2025/009, ТТОВА/2025/011, ТТОВА/2025/013 дугаартай нүүрс нийлүүлэх гэрээнүүдийн дагуу 288,000.00 тонн нүүрсийг уурхайгаас нүүрс ачиж буулгах талбай руу ачуулах ёстой хэдий ч уурхайгаас ачигдаж буй нүүрсний тоо хэмжээнд тавих дотоод хяналт хангалтгүйн улмаас 3,977.7 тонн нүүрс илүү ачигдсан байна.	1	1,414,148.6			1	1,414,148.6						
14	“Смарт эко транс” ХХК-ийн AGV буюу Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал дахь нүүрсний хөдөлгөөний мэдээ, борлуулалт тээврийн хэлтсийн борлуулалтын мэдээнээс 1,088.7 тонноор зөрүүтэй байна.	1	110,120.8			1	110,120.8						
15	Компанийн 2025 оны 12-р сарын 31-ны өдрөөрх сэлбэгийн үлдэгдэлд шинжилгээ хийхэд сүүлийн 2 жил хөдөлгөөнд ороогүй 364 нэр төрлийн 4,226 ширхэг 444,016.8 мянган төгрөгийн сэлбэгийн үлдэгдэл байна	1	444,461.0					1	444,461.0				
16	Биржийн арилжаанд ялсан харилцагчийн Монголын Хөрөнгийн биржид байршуулсан дэнчингийн тооцоог компани санхүү бүртгэлд тусгаагүй байна	1	-					1	-				

Тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

17	Таван толгой ХК-ийн нүүрсний биржийн арилжаанд тогтоосон үнийг зах зээл дээр ижил төрлийн нүүрс арилжаалж буй Эрдэнэс таван толгой ХК-ийн арилжааны үнэтэй харьцуулахад Эрдэнэс таван толгойн дуудах үнээс доогуур үнээр хэлцэл хийсэн байгаа бөгөөд энэ нь борлуулалтын орлого, ашигт ажиллагаа буурах эрсдэлтэй байна	1	-					1	-				
18	Нэр бүхий 6 компанийн нүүрс буулгах талбайд 2023-2024 онд буулгасан 247.9 мянган тонн нүүрс байна. Тухайлбал Ногоолин хэрлэн ХХК-ийн талбайд 2023/007 гэрээний 57.8 мянган тонн, Энхдэлгэр говь ХХК-ийн талбайд 2023/005 гэрээний 0.8 мянган тонн, 2024/008 гэрээний 0.1 мянган тонн, Тахидаг хайрхан ХХК-ийн талбайд 2024/016 гэрээний 2.2 мянган тонн, 2024/017 тоот гэрээний 32.4 мянган тонн, Ёл ресурс ХХК-ийн талбайд 2024/007 гэрээний 57.7 мянган тонн, 2024/017 гэрээний 25.1 мянган тонн, Эрхэм сүлд монгол ХХК-ийн 2023/005 гэрээний 0.2 мянган тонн, 2023/009 гэрээний 25.0 мянган тонн, 2023/017 гэрээний 32.1 мянган тонн, 2024/010 гэрээний 0.3 мянган тонн, 2024/016 гэрээний 14.1 мянган тонн нүүрс тус тус байна	1	-					1	-				
19	Бараа материалын жилийн эцсийн тооллогод хяналтаар оролцон 21 нэр төрлийн 966 ширхэг 450,643.5 мянган төгрөгийн сэлбэг тоолоход 1 нэр төрлийн 25 ширхэг 7,690.1 мянган төгрөгийн сэлбэг тухайн үед дутуу байсан ба маргааш өдөр нь дутуу сэлбэгийг видео дуудлага хийн тоолуулсан. Компанийн агуулах дахь бараа материалын байрлал, тэмдэглэгээ тодорхойгүй, зохион байгуулалт, эмх цэгц маш хангалтгүй байна.	1	7,690.1					1	7,690.1				
20	Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг тухайн хөрөнгийн эдийн засгийн насаар бус татварын хуульд тусгагдсан жилээр элэгдүүлж байгаа нь үндсэн хөрөнгийн стандарттай нийцэхгүй байна	1	-					1	-				
21	Ford 5588 ӨМЭ суудлын автомашин нь компанийн эзэмшлийнх биш хэдий ч авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн лавлагаанд бүртгэлтэй хэвээр байна	1	-					1	-				

Тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

22	Хөрөнгийн хуучралт, элэгдэл эсвэл биет эвдрэл гэмтэл, хүрээлэн буй орчин эдийн засаг, зах зээл, технологийн хоцрогдол зэргийг үндэслэн үндсэн хөрөнгийн дансанд үнэ цэний бууралтын тооцоолол хийгээгүй байна.	1	172,673.7-					1	172,673.7-				
23	Компани нь эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээх хуулийн эсвэл үүсмэл өнөөгийн үүрэг хариуцлага хүлээж байгаа ч тайлант онд уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн нөөц болон холбогдох хөрөнгийн бүртгэлийг НББОУС-ын дагуу тооцон бүртгээгүй байна.	1	-					1	-				
24	Байгууллага нь СТОУТХ 20-д тусгагдсан хөрс хуулалтын зардлыг хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх үндсэн 3-н шалгуур үзүүлэлтийг зэрэг хангаагүйгээс ил уурхайн олборлолт болон үйлдвэрлэлийн шатанд хуримтлагдах уурхайн хаягдал зайлуулах (хөрс хуулалтын) зардлуудыг стандартын дагуу бүртгээгүй буюу бүртгэх боломжгүй байна	1	-					1	-				
Дүн		24	39,303,613.8	-	-	14	38,678,789.0	10	624,824.8	-	-	1	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил													
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй шууд худалдан авалтаар нийт 796,001.6 мянган төгрөгийн төмөр замын гармын төлбөр, чингэлэг тээврийн терминалын үйлчилгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан боловч тендер зарлаагүй шууд худалдан авсан 5,564,983.0 мянган төгрөгийн нүүрс ачиж буулгах талбайн түрээс, түлш шатахуун, харуул хамгаалалт, машин тоног төхөөрөмжийн сэлбэг, тавилга эд хогшил, хурлын тоног төхөөрөмж, кондейшн, программ хангамж, компанийн "Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам"-ыг баримтлаагүй 87,994.1 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.	1	6,547,370.3			1	6,547,370.3						

Тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2	Ковшийн хөдөлгүүрийн сэлбэг худалдан авах, их засварын ажлын 62,488.2 мянган төгрөгийн шууд худалдан авалтыг өөр албан ёсны эрхтэй нийлүүлэгч байхгүйг нотлох анхан шатны баримтгүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн байна.	1	62,488.2			1	62,488.2						
3	Гүйцэтгэх захирлын 2025 оны А/023 дугаар тушаалаар баталсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын 5 дугаар зүйлийн 5.7-д "Үнэлгээний хороо нь хуралдаанаа цахим хэлбэрээр зохион байгуулж болох бөгөөд архив, бичиг хэргийн стандартын дагуу үнэлгээний хорооны зөвлөмж, хуралдааны тэмдэглэл болон холбогдох баримт бичгийг цаасан хэлбэрээр баталгаажуулж ажиллана" гэж тусгасан байна.	1	-			1	-						
4	Тендерийн бичиг баримтад тусгасан хүний нөөцийн шаардлага, ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын нотлох баримт дутуу оролцогчийг сонгон шалгаруулан Цогтцэций суманд 40 га-д худаг барих, хөрөнгийн үнэлгээ хийх нийт 158,843.2 мянган төгрөгийн ажил гүйцэтгүүлсэн мөн худалдан авах тоо, хэмжээ, үнийг тендерийн нийт өртөгтэй уялдуулаагүйгээс 267,198.0 мянган төгрөгийн АИ-92 бензин болон 156,816.0 мянган төгрөгийн тос, тослох материал худалдан авах тендерүүд тус тус хүчингүй болсон байна	1	582,857.2			1	582,857.2						
5	Гүйцэтгэх захирлын А/013, А/022 дугаар тушаалуудаар аж ахуйн нэгж байгууллагуудаас авах авлага барагдуулах 2 удаагийн ажлын хэсэг байгуулан ажилласан боловч ажлын үр дүнг хэлэлцээгүй, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар биелэгдээгүй, тушаалын хэрэгжилт хангагдаагүй байна	1	-			1	-						
6	Өмгөөллийн чиглэлээр нэг төрлийн үйлчилгээ авахдаа сонгон шалгаруулалтгүй шууд гэрээ байгуулж үйлчилгээ авсан байна	1	57,000.0			1	57,000.0						
7	Тайлант оны эхний 8-н сар олборлолт хийгээгүй компанийн үндсэн үйл ажиллагаа нь зогсонги байсан ч бодит нөхцөлтэй уялдуулан бизнес төлөвлөгөө болон худалдан авах ажиллагаа /ХАА/-ны төлөвлөгөөнд өөрчлөлт, тодотгол хийгээгүй. Компанийн бизнес төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүд нь тодорхой бус нэгтгэгдсэн мөн батлагдсан бизнес төлөвлөгөөтэй уялдаагүй бараа ажил, үйлчилгээг ХАА-ны төлөвлөгөөнд тусгасан байна	1	21,972,165.2					1	21,972,165.2				

Тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

8	Тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээний дагуу сар бүр гэрээний 8.5 дах заалтад " Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлыг сар бүр гаргаж, хасагдах оноо тус бүрийг тухайн сард гүйцэтгэх төлөвлөгөөт тэсэлгээний ажлын мөнгөн дүнгийн 0.01%-р үржүүлэн гүйцэтгэгчид төлөх нийт төлбөрөөс хасаж тооцно гэж заасан бол уг гэрээний хавсралт-3-ын 3.3-д КРІ үнэлгээнээс хамаарч 0.01%-0.05% хүртэл үржүүлж хасна гэсэн заасан байна. Компани гэрээний 8.5 заалтаа барьж тэсэлгээний ажлын төлбөрийг тооцоолж байгаа хэдий ч төлбөрөөс хасах дүнг тооцоолох 2 өөр хувилбар гэрээнд тусгагдсан байна	1	-					1	-				
9	Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг сүүлийн 3 жилээр харьцуулан дүн шинжилгээ хийхэд хэрэгжилт дунджаар 33.0 хувьтай байна	1	-					1	-				
10	Компанийн урт хугацааны стратеги төлөвлөгөө болон дунд хугацааны төлөвлөгөө байхгүй, компанийн хэтийн зорилго, зорилт тодорхой бус байгаа нь бизнесийн төлөвлөгөө бодитой боловсруулагдах, биелэлт хангалтгүй байх үндэс суурь болж байна	1	-					1	-				
11	Цогцэций суманд 40 га-д байгуулах Худгийн ажлын даалгаврыг байгаль орчны ахлах мэргэжилтэн боловсруулж, хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн хянаж, Уул уурхайн технологийн газрын захирал зөвшөөрсөн боловч гарын үсэггүй Гүйцэтгэх захирал баталсан байна.	1	100,000.0					1	100,000.0				
12	Тээвэр болон борлуулалттай холбоотой гэрээний үүргийн биелэлтийг тухай бүр нь дүгнэж, тооцоо нийлсэн актыг үйлдэж хариуцсан мэргэжилтэн нь цаг тухай бүрд нягтлан болох бүртгэлийн хэлтэст танилцуулахгүй байгаатай холбоотой он дамжсан гэрээний төлбөр үүссэн, цаашид нэмж үүсэх эрсдэлийг бий болгож байна	1	-					1	-				
Дүн		12	29,321,880.9	-	-	6	7,249,715.7	6	22,072,165.2	-	-	-	-
Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													
1	Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг компанийн дүрэмд 52,665.2 мянган төгрөгөөр, санхүүгийн байдлын тайланд 94,487.6 мянган төгрөгөөр, компанийн гэрчилгээнд 94,480.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тусгагдсаныг холбогдох шийдвэрийн дагуу санхүү байдлын тайланд зөв дүнгээр тусгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй байна	1	41,822.4					1	41,822.4				

Тавантолгой ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2	Санхүүгийн байдлын тайланд бүртгэлтэй 658,153.4 мянган төгрөгийн ногдол ашгийн өглөг нь 2022 оноос хойш хөдөлгөөн гараагүй, өглөгийн үлдэгдлийг бөөн дүнгээр “Тавантолгой” ХК гэсэн харилцагчаар бүртгэсэн, харилцагчийн нэр, хэзээ төлөх нь санхүү бүртгэлд тодорхойгүй, үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй байгаа зөрчлийг арилгах өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна	1	658,153.4			1	658,153.4						
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлээгүй, өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна	1	-			1	-						
4	Компанийн үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглагдаж байгаа 8 нэр төрлийн 375 ширхэг хөрөнгийг дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх саналыг холбогдох байгууллагад хүргүүлэн, шийдвэрлүүлэх, стандарт, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	-				-						
Дүн		4	699,975.8	-	-	4	699,975.8	-	-	-	-	-	-
Нийт дүн		16	30,021,856.7	-	-	10	7,949,691.5	6	22,072,165.2	-	-	-	-